

МОНГОЛЫН ТӨР- ШАШНЫ ХАРИЛЦАА: ХУБИЛАЙ ХААНЫ БОДЛОГО

Ч.Дамбажав- Дашчойлинхийдийн Хамба лам

Түлхүүр үгс: Шашин төрийн ёс, Бурханы сургаал, Төвдийн буддизм, Сажал лам, Хубилай хаан, Юань гүрэн, Азийн буддизм, Очирт хөлгөн, Цагаан түүх, Чойжи-Одсэр

Товч утга: Хубилай хааны үеэс Монгол орон очирт хөлгөнд орохын эх тавигдсан гэж үзэх нь буй. Монголын их гүрний доторхи нийт улс түмнийг шашин, төрийн хос бодлогоор засаглан барих бодлого энэ үест хэрэгжиж байжээ. Үүний онол, үзэл санааны үндэс нь төр, шашин хоёрын холбоонд тулгуурласан хос ёсны сургаал байлаа. Энэ нь нэг талаас хууль цааз, цэргийн биет хүч, нөгөө талаас ухаан билиг, зан суртахууны сэтгэлийн хүч хоёрыг төрийн бодлогод нэгтгэн барих ёс байв. Буддизм Монголд дэлгэрсэн нь Монгол болон Дундад Азийн орнууд, Монгол болон Энэтхэгийн харилцаа, улмаар Монгол-Төвдийн харилцааны нэгэн гол шижим болжээ.

Төрийг хууль цаазны зэрэгцээ сэтгэл, оюуны хүчээр хамтатган барьж төвшитгөх Их Монгол улсын төрийн бодлогыг гүнзгийрүүлэн хэрэгжүүлж, хааны төр, бурханы шашин хоёрын нягт холбоог тогтоон бэхжүүлсэн нь Хубилай хааны үе болно. Хубилай их хаанд өргөмжлөгдөхөөсөө бүүр өмнө Годан ноёны нөлөөгөөр бурханы шашин, тухайлбал, төвдийн сажабагийн ёс, түүний бие төлөөлөгч Пагва ламтай (1253 он) танилцсан байв. Пагва лам Лодойжалцан хэдийгээр нас залуу боловч, хар багаасаа авга Гунгаажалцангийн дэргэд байж, бурханы шашны эрдэм номд сайтар суралцсан, түүнийг дагаж Монголд ирснээс хойш эндээ тасралтгүй сууж, төр шашны хос ёсны сургаал, дадалд сүрхий мэргэжиж хэрсүүжсэн бололтой. Тэр бээр анхныхаа уулзалтаар л Хубилайд өөрийн шид эрдмээр нөлөөлж, Хубилай Пагва ламаас хэвжэрын авшиг авсан гэж түүх сударт өгүүлдэг. Энэ үеэс ч Багш лам болон Өглөгийн эзний барилдлага үүсжээ. Энэ нь Их Монгол улсын төр, шашны цаашдын түүхэн хөгжилд их учир холбогдолтой байв. Үүгээр Монгол орон очирт хөлгөнд орохын эх тавигдсан гэж үзэх нь ч буй.

Хубилай 1260 онд Их Монгол Улсын хаан ор сууж, тэр жилдээ Пагва ламд Улсын багш (гуо шри) цол өргөмжилж, гүрэн улсын бурханы шашныг мэдүүлсэн байна. Пагва ламд өргөмжлөл өгч, авшиг авсаны хариуд Хубилай хаанд Төвдийн бүх чуулган чөлхийг барьжээ. Хаан улмаар Бурханы шашин ба Төвдийн явдлыг эрхлэх яам байгуулан Пагвад мэдүүлж, Төвдийг шашны хувьд сажаваар толгойлуулан нэгтгэн барих бодлогыг хэрэгжүүлжээ.

Энэ нь Монгол, Төвдийн харилцааны нэн нарийн үе байсан бөгөөд Монголын их гүрний хувьд Төвдийг шашнаар дамжуулан нэгтгэн барих, зөвхөн Төвдөөр зогсохгүй, гүрний доторхи нийт улс түмнийг шашин, төрийн хос бодлогоор засаглан барих, Төвдийн хувьд бурханы шашнаар дамжуулан Их Монгол улсын ивээлд багтаж, түүгээр ч зогсохгүй Монголын төрд өөрийн нөлөөг үзүүлэх, сажава ёсны хувьд Их хааныг түшиглэн Төвд дэх өөрийн байр сууриа бэхжүүлэн, Төвдийн бурханы шашин хийгээд нийт Төвд орны тэргүүлэх нөлөө бүхий шүтлэг болох эрмэлзлэл эдгээр бүхэн харилцан сүлжилдэж, хэн алины тусад зохицлыг олон хэрэгжиж байжээ.

Эл бүхний онол, үзэл санааны үндэс нь төр, шашин хоёрын холбоонд тулгуурласан хос ёсны сургаал байлаа. Тус сургаалыг онолын хувьд боловсруулан тавьж, төрийн практикт хэрхэн хэрэглэхийг заан тодорхойлсон тэр үеийн алдартай бүтээл нь "Арван буянт номын цагаан түүх" болно. Уг зохиол Хубилай хааны удаа дараа гаргаж мөрдүүлсэн зарлиг, өргөмжлөл, Пагва ламын номлосон бурханы шашны сургаал, зан үйлийг үндэс болгон тулгуурласан байна.

Энд хос ёсны сургаалыг боловсруулан баримтласан бөгөөд түүний утга санаа, агуулга, шинжийг манай эрдэмтэд судлан харуулжээ¹⁰².

Энэ нь хууль цааз, цэргийн биет хүч, нөгөө талаас ухаан билиг, зан суртахууны сэтгэлийн хүч хоёрыг төрийн бодлогод нэгтгэн барих ёс байв. Эл хоёр хүчнийг хослуулах нь төвч мэргэнээр харах төрийн бодлогыг иргэн ардаа билгийн хурц, сэтгэлийн энэрэнгүйд хүргэх буддын шашны номын ёстой хослуулах гэсэн хэрэг юм. Монгол төрийн энэ ёс бол төр нь иргэндээ өршөөлтэй, иргэн нь төрдөө ачлалтай байх зарчимд суурилах учиртай байв.

“Цагаан түүх” зохиолд: “Үнэн номын засаг хэвийн зангиа мэт алдаршгүй, хүнд хааны засаг алтан буулга мэт эвдэршгүй”¹⁰³ гэж томъёолоод, “Хоёр ёсыг аль буй хэмээвээс: номын төр тарни, судар хийгээд ертөнцийн төр энх, хялбар” болно, “номын засаг үгүй бөгөөс амьтнууд тамд унаж, хааны засаг үгүй бөгөөс улс аймаг эвдрэх больюу”¹⁰⁴ хэмээн тодорхойлжээ. Ингэж бурханы зарлиг, хааны засгаар явж л байж хүмүүс аз жаргалтай, энх амгалан байж чадна гэж үзэж байв.

Хоёр ёсны үзлийг номлосон “Цагаан түүх” зохиолд: төрийн бодлого, үйл ажиллагааг гурван их үйл, дөрвөн их төр, зургаан их үлгэр, долоон их бин, есөн их бэлгээр тодорхойлжээ¹⁰⁵.

Гурван их үйл нь: 1) улс олныг номын ёсоор засаж амгалан болгох, 2) төрийн ёсоор засаж жаргал эдлүүлэх, 3) цэргийн явдлыг хичээж улсыг батлан хамгаалах энэ гурав болой. Энэ гурван их үйл бол монголын хааны төрөө засахын үндсэн үзэл санаа бөгөөд Хубилай хааны байгуулсан Юань гүрний үед эдгээр үүргийг хааны өмнөөс засаг төрийг явуулагч хонжин хэмээх нэртэй гурван тэргүүн түшмэл тус тус эрхлэн гүйцэтгэж байжээ.

Дөрвөн их төр нь: 1) Их хөлгөний ёсны жаргалангийн төр, 2) Нууц хөлгөний ёсны жагаа (үнэн) төр, 3) Хааны баригч энх төр, 4) Түшмэдийн баригч дайчин төр эдгээр болно. Эхний хоёр нь хамаг амьтны тусын тулд их нигүүлсэхүй сэтгэл гаргаж, хүн зоныг адил тэгшээр үзэн тусалж, тэдэнд үнэн мөрийг заах, дараагийн хоёр нь Хаанаас төр барихдаа энх амгаланг эрхэмлэх, сайд, түшмэдүүдээрээ төрийг шударга бөгөөд сайтар засуулахыг үндсэн зарчим болгосон байна. Дөрвөн их төр нь монголын хаан бурхан суртахууныг төрийн үзэл суртал болгож, шашин төр хоёрыг тэгш явуулах, тэгэхдээ ялгаж үзэхийг үндэслэн заажээ.

Зургаан их үлгэр нь: 1) ертөнцийг байгуулсан тооны үлгэр, 2) бурханы санг байгуулсан вивангиридын үлгэр, 3) засгийг явуулахуй байгуулсан ёслохуйн үлгэр, 4) зургийг байгуулсан хэмжээний үлгэр, 5) цэргийг байгуулсан төвлөрүүлэхүйн үлгэр, 6) хүү санг байгуулсан арвитгахуйн үлгэр - эдгээр болно.

Долоон их бин нь: 1) өнгөрснийг хөөж онох гүн ухааны бин, 2) ирээдүйг угтаж мэдэх дээд оточийн бин, 3) битүүг тааж онох үлэмж мэргэн, 4) эдүгээ ахуйг төгс онох магад мэдэхүй, 5) бусдын самбаа өгүүлэхийг урьдаас онож мэдэх гайхамшигт цэцэн, 6) аян, авын зүйлийг ёсоор мэдэхүй чадал баатарын бин, 7) таван ухааныг төгсгөхүй гэгээн билгийн бин эдгээр болно. Долоон их бин нь монголын хаад оюун билиг, эрдэм мэдлэгийг эрхэмлэн хүндэтгэж, битүүг ухан чадаж, үйлс, бүтээлдээ хэрэглэхийг

¹⁰² Ш.Бира, БНМАУ-ын түүх, соёл, түүх бичлэгийн асуудалд, УБ., 1977 он, 196-206 дахь тал; Ч.Жүгдэр, Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ, хоёр дахь хэвлэл, УБ., 2002, 145-152; Ч.Далай, Монголын түүх (1260-1368), УБ., 1992, 50-64 дэх тал, Г.Лхагвасүрэн, "Арван буянт номын цагаан түүх", монгол төрт ёсны сэтгэлгээний хөгжил, - *Монголын фи*

лософийн түүх, II дэвтэр, УБ., 2000, 234-281 дэх тал

¹⁰³ Арван буянт номын цагаан түүх, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1981, 72 дахь тал.

¹⁰⁴ Арван буянт номын Цагаан түүх, 76 дахь тал.

¹⁰⁵ Арван буянт номын Цагаан түүх, 84-85 дахь тал.

онцгойлон анхаарч байсныг гэрчилж байна. Хаан, түүний сайд, түшмэдүүд бол мэргэн цэцэн, эрдэм мэдлэг сайтай, чадвартай бөгөөд баатар байх ёстой гэж үзэж, энэ зарчмыг ажил амьдрал дээрээ баримтлан хэрэгжүүлж, хан хөвгүүд, сайд, түшмэдийг хүмүүжүүлэх, шилж сонгоход онцгой анхаарч байсан байна.

Есөн их бэлгэ нь: 1) түг түмэн цэрэг аялуулах хараа ихт хар туг бусдыг айлгахын бэлгэ, 2) бүгдийг хөдөлгөх хашираа ихт улаан бүрээ хамаг бүхнээ хүндэтгэхийн бэлгэ, 3) хүч ихт алтан хуур бие сахирын бэлгэ, 4) цог ихт шар шүхэр олноо өргөгдөхийн бэлгэ, 5) зангараг ихт алмас илд засаг явулахын бэлгэ, 6) чийрэг сайн алтан эмээл явдлыг бэлгэ, 7) эхил ихт хүнд бүс төр тогтоохын бэлгэ, 8) өндөр тавцант исэр (суудал) хүндэт суудлын бэлгэ, 9) түшээ сайт өрлөгүүд анд нар арга билгийн бэлгэ эдгээр болно. Монгол төрийн хүндэтгэлийн эдгээр бэлгэдэлд уламжлалт монгол зан зашлын зэрэгцээ бурханы шашны бэлгэдлийн зүйл шар шүхэр, улаан бүрээ, исэр зэрэг хослон орсон байна. Ер Хубилай хааны үед Пагва ламын санаачилгаар шашны зан үйл, том ёслолуудыг тогтоосны нэг нь цагаан шүхэр бөгөөд түүгээр Их хааны хуучин Найман хөхөлт цагаан тугийн сүлдийг сольсон байна. Улмаар Хар тугийн сүлдийг Хар Махагалаар сольсон гэх жишээтэй.

Төрийг тэгш төвшинөөр засан явуулахын учир номын ёсоор засаж амгалан байлгах, төрийн ёсоор засаж жаргал эдлүүлэхийг зорилт болгож, түүндээ Монгол төрийн түүхийн үлгэр дууриаллыг авах, Бурхан багшийн сургаал, номын ёсны дууриаллыг дагах, оршин буй цаг үеэ өнгөрсөн хийгээд ирээдүйтэй холбон уг үндсээр нь таних, тухайлбал өнгөрснийг хөөж онох, ирээдүйг угтаж харах, битүүг тааж ухаарах, эдүгээг бүрэн шинжиж мэдэх билиг эрдмийг эзэмшин түүгээр төрийг залах зэргийг ийнхүү ангилан өгүүлсэн байна. Хубилай хаан энэ бодлогыг баримтлан хэрэглэж чадсанаар Монголын Юань гүрний төрийг 30 гаруй жил бататган барьжээ.

Их Монгол Улсын үед Эзэн хааны ордноо тэргүүлэн буддын шашин дэлгэрч, бурханы шашны ном зохиолыг орчуулах, судлах талаар ихээхэн ажлыг өрнүүлж байжээ. Тэр үед Их Хөлгөний онолын урсгал голлон дэлгэрч байсан нь ойлгомжтой, тэр дундаас Төвдөд хүчтэй дэлгэрч хөгжсөн буддизмын уламжлал гол нөлөөтэй байжээ.

XIII зууны эцсээс XIV зууны үед бурханы шашны ном зохиол орчуулах, судлах, сурталчлах ажил нэлээд өргөжиж ирсэн тухай баримт мэдээнүүд бий. Тэр үед орчуулсан буддын онолын ном зохиолын дотор билиг барамидын судрууд, түүнчилэн вумын гүн ухааны ном зохиол, мөн уншлага, ерөөл, магтаал, төр-шашны сэдэвт шастарууд голлож байсан гэж үзэж байна.

Бурханы шашин, номын үйлсэд бие, сэтгэлээ зориулж, Ялгуусны сургаалыг судлах, номлох, бүтээх талаар ихээхэн зүйл туурвиж хийсэн гүүшри, мэргэд цөөнгүй төрж гарсан нь мэдээж бөгөөд тэдний дотроос өнөөдөр бидэнд зохиол бүтээлийнх нь тухай мэдээ баримт уламжлагдан ирж чадсан нэгэн эрдэмтэн сэтгэгч бол Чойжи-Одсэр бандида юм. Их Монгол улсын үед бурханы шашны гүн ухааны ном зохиолыг орчуулж, тайлбарлаж байсан тухай мэдээг анх академич Ц.Дамдинсүрэн олж тогтоосон байна. Энэ нь Турфаны монгол цуглуулгад байсан 12 хуудсыг академич Берлин хот дахь Үндэсний музейгээс нээн олсноор эхэлсэн билээ¹⁰⁶. Түүнээс хойш монголч эрдэмтэд энэ чухал олдворыг ихэд үнэлэн сонирхож, нарийвчлан судалжээ¹⁰⁷.

Эрдэмтэн Д.Цэрэнсодном Чойжи-Одсэрийн намтар, бүтээлийг тусгайлан судалсан байна¹⁰⁸. Энд дурдан буй 12 хуудас бол Чойжи-Одсэр бандида бээр VII зууны

¹⁰⁶ Ц.Дамдинсүрэн, Ардчилсан Герман улсын Шинжлэх ухааны Академиар орсон тухай тэмдэглэл – "Шинжлэх ухаан", № 3, 1954.

¹⁰⁷ F.W.Cleaves, The Bodistwa-ačari-a awatar-un tayilbar of 1312, HJAS, Vol.19, 1954; E.Haenisch, Mongolica. Der Berliner Turfan-Sammlung. I. Ein buddhistisches Druckfragment vom Jahre 1312, Berlin, 1954; F.Weller, Zum Blockdruckfragmente des mongolischen Bodhicharyawatara der Berliner Turfan-Sammlung, Berlin, 1955.

¹⁰⁸ Д.Цэрэнсодном, XIV зууны үеийн яруу найрагч Чойжи-Одсэр, УБ., 1960.

үеийн мадхьямака философийн нэрт төлөөлөгч, яруу найрагч Шантидевагийн “Бодьсатвын явдалд орохуй” зохиолыг монгол хэлнээ орчуулаад, түүнд том хэмжээний тайлбар хийж хэвлүүлсний төгсгөлийн хуудсууд юм. Энэтхэгийн буддын гүн ухааны нэн нарийн найраглалыг орчуулаад зогсохгүй, өөрийн тайлбарыг зохиож байсан нь XIII зууны үед Монгол оронд гүн ухааны сэтгэлгээ хөгжлийн нэлээд өндөр төвшинд байсныг илэрхийлж байна. Тэр цагийн мэргэд мөн бурханы шашны гүн ухааны нарийн утга учирт сайтар мэргэжсэн байсныг тус зохиолын төгсгөлийн үгнээс харж болно. Үүнд:

“Их хөлгөн номын гүн ахуй үзэл, явдлыг ухуулахуй Чаръя-Аватара нэрт шастирын тайлбарыг Хааны зарлигаар агам юкти номуудад сайтар дадсан би Чосги Одсэр аягха тэхимлиг гахай жил намрын тэргүүн сарын нэгэн шинэдээ зохиож дуусвай”,

“Хамаг монголжин хэлтний тулд

Гайхамшиг Чаръя-Аватарын талурай утгасыг

Хамж, судар номуудын гэрэ үгсээр

Хагархайяа Чосги-Одсэр тойн зохиовай” гэх зэргээр бичсэнийг үзэхэд бурханы шашны онол, ухааны мэдлэг үлэмж сайтай байсан нь илэрхий. Чойжи-Одсэр бандида бурханы зарлиг, шастирын номыг монгол хэлээр орчуулагч гүүш нарын манлай, багшийн багш байсан төдийгүй дуун ухаан, тухайлбал зохист аялгуу, эвсүүлэн найруулах тэргүүтэнд гарамгай мэргэжсэн билиг танхай гэгээн эрдэмтэн байжээ. Ялангуяа Шиванлхаа гэгээний “Бодь мөрийн явдалд орохуй” зохиолыг монголоор орчуулан, үг утга тэргүүтнийг зохилдуулан тайлсныг нь гадаад, дотоодын мэргэд монголчуудаас буддын гүн ухааны сэтгэлгээнд оруулсан том хувь нэмэр хэмээн үнэлдэг юм. Бандид Чойжи-Одсэрийн бичиж, 1312 онд Дадүгийн цагаан суваргад 1000 хувь барлуулсан эл зохиолыг төвдийн алдарт эрдэмтэн Бүдөн (1290-1364) гэгээний тайлбараас түрүү гарсан гэж судлагчид үздэг байна.

Тэрчлэн Чойжи-Одсэр “Банзрагч” судрыг монгол хэлнээ орчуулж, яруу сайханаар шүлэглэсэн төгсгөлийн үг бичжээ. Банзрагч бол тарни ихтэй, хэллэг хүндтэй ном юм, иймээс ч монголчуудын дунд “бардам бандиар Банзрагч уншуул, бардам хүүхнээр панс оёул” гэсэн хэллэг ч гарсан байдаг. Ийм судрыг монголчилно гэдэг түүний эрдэм чадал ямар болохыг илэрхийлж байна. Судрын төгсгөлийн үгэндээ амгалан энхийн ерөөл тавьж бичихдээ:

“Үлэмж нигүүлсэхүй сэтгэлийн үүлнээс

Үхэл үгүй номын хурыг оруулж,

Орчлонгийн чилгэр халууныг сөнөөгчидөө

Оройгоор хүндлэн мөргөж бүрүүн ...

Амьтан нэгэн нэгэндээ сургалдаж

Аядуулдаж сайн сэтгэлээн амарлиж,

Амраг эх хөвгүүн бэ мэт

Асрахуй нигүүлсэхүй сэтгэлтэн болтугай” гэх мэтээр бүгдийг энх амгалан, эв зохицолтой байхыг ерөөж, нигүүлсэхүй их сэтгэлийг хамгийн эрхэмд үзэн дээдэлдэг тухай санаагаа илэрхийлсэн байна.

Чойжи-Одсэр ном бүтээл орчуулаад зогсохгүй, мөн өөрөө бие даасан бүтээл зохион туурвиж байжээ. Үүнд “Бурханы арван хоёр зохионгуй” хэмээх Бурхан багшийн намтар түүх хоёр боть номыг төвд хэлээр зохиожээ. Түүнийг тэр үеийн монголын нэрт орчуулагч, бичгийн хүн Шаравсэнгэ монголчлон хөрвүүлжээ. Мөн Махагалын магтаал

шүлэглэлийг бичсэн байна. Түүний шүлэг найргийн эрдэм, уран тансаг хэллэгийн тухай эрдэмтэн Д.Цэрэнсодном тусгайлсан судалгаа хийсэн байна¹⁰⁹.

Чойжи-Одсэр түүнчилэн хэл бичгийн өндөр боловсролт эрдэмтэн байсан бөгөөд монгол хэлний хэл зүйн анхны бүтээл болох "Зүрхэн тольтыг" зохиожээ. Түүнийг дараа үеийн монголын уламжлалт хэлний шинжлэлтэнүүд ашиглан монгол хэлний зүйг боловсруулж иржээ. Ийнхүү Чойжи-Одсэр бол бурханы шашны гүн ухаан, онолын мэдлэгт сайтар мэргэшсэн гүн ухаантан, монгол, уйгар, төвд, санскрит зэрэг хэлийг сайтар эзэмшсэн өндөр боловсролтой, их мэдлэгтэй сэтгэгч мэргэн байжээ.

Эл бүхнээс дүгнэн үзвэл ХIY зууны үе гэхэд монголчууд бурханы шашныг зөвхөн хүлээн авч дэлгэрүүлж байсан төдийгүй номлох, бүтээх, туурвих, баяжуулах өндөрлөгт хүрсэн гэж баттай хэлж болно.

Буддизм Монголд дэлгэрсэн нь ийнхүү Монгол болон Дундад Азийн орнууд, Монгол болон Энэтхэгийн харилцаа, улмаар Монгол-Төвдийн харилцааны нэгэн гол шижим болжээ. Монголын буддизмын үндсэн нэр томъёонууд гол төлөв санскрит хэлээр байдаг нь монгол-энэтхэгийн соёлын харилцааны илрэл мөн. 2000 гаруй жилийн тэртээгээс үндэстэй Монгол, Энэтхэгийн харилцааны түүхэнд дайтах эзэрхэх биш, харин энх амгалангийн, шашин-соёлын харилцаа ноёлж иржээ. Монгол-Энэтхэгийн харилцаа монгол үндэстний түүхэнд эрхэм сайхан үр нөлөө үзүүлсэн юм. Ер Монголын нэгдсэн гүрэн задарч, бутрал гүнзгийрэн, өөр зуурын тэмцэл зөрчилдөөн ихэссэн үед монголчууд харийн нөлөөлөлд автагдах аюул бодитойгоор нүүрлэж байв.

Улмаар Монгол улс Хятадад тогтож байсан Манж гүрний эзэмшилд орж, тусгаар тогтнолоо алдсан билээ. Гэхдээ энэ үед асуудлын гол нь Хятадын соёл иргэншлийн уусгах нөлөөг хааж, үндэсний өвөрмөц байдлаа хэтдээ хадгалах явдал байв. Монголын төр, шашны зүтгэлтнүүд уг асуудлыг өөрийн холч мэргэн ухаанаар шийдэж, Монгол орон буддын шашинаар дамжин Энэтхэгийн соёлын хүрээнд онцлог байдлаар хамрагдах болсон нь Хятадын соёл, иргэншлийн уусгах нөлөөлийг хааж чадах нэгэн үндэс болсон билээ. Тухайн үедээ Хятад дахь их гүрний эзэн болж, Монголыг эрхэндээ дагуулсан манж нар эдүгээ биеэ даасан үндэстний хувьд уусаж мөхсөн байхад монголчууд бие даасан улсаа сэргээн хадгалж, үндэстний хувьд тэсэн үлдэж чадсан юм. Ийнхүү бурханы шашин моголчуудын хувьд улс үндэснийхээ өвөрмөц байдал, тусгаар тогтнолыг хадгалж үлдэхэд онцгой чухал үүрэг гүйцэтгэжээ.

Тэгэхдээ монголчууд буддизмыг өөрийн өвөрмөц нөхцөлд бүтээлчээр хүлээн авсан бөгөөд буддын шашин ард түмний зан заншил, ёс суртахууны уламжлалтай нягт уялджээ. Ингэж монголын бэлчээрийн нүүдлийн мал аж ахуй, бурханы шашин хоёр бол улс, ард түмний өвөрмөц онцлогоо хадгалах, улс төрийн хувьд бие даан тогтон хөгжих нэг гол хүчин зүйл болсон байна.

¹⁰⁹ Д.Цэрэнсодном, ХIY зууны үеийн яруу найрагч Чойжи-Одсэр, УБ., 1969.

Ном зүй

- Арван буянт номын цагаан түүх, Өвөр Монголын ардын хэвлэлийн хороо, 1981
- Ш.Бира, БНМАУ-ын түүх, соёл, түүх бичлэгийн асуудалд, УБ., 1977
- Ц.Дамдинсүрэн, Ардчилсан Герман улсын Шинжлэх ухааны Академиар орсон тухай тэмдэглэл – “Шинжлэх ухаан”, № 3, 1954
- Ч.Жүгдэр, Монголд феодализм тогтох үеийн нийгэм-улс төр, гүн ухааны сэтгэлгээ, хоёр дахь хэвлэл, УБ., 2002
- Монголын философийн түүх, II дэвтэр, УБ., 2000
- F.W.Cleaves, The Bodistwa-ačari-a awatar-un tayilbar of 1312, HJAS, Vol.19, 1954;
- E.Haenisch, Mongolica. Der Berliner Turfan-Sammlung. I. Ein buddhistisches Druckfragment vom Jahre 1312, Berlin, 1954;
- F.Weller, Zum Blockdruckfragmente des mongolischen Bodhicharyawatara der Berliner Turfan-Sammlung, Berlin, 1955.
- Д.Цэрэнсодном, XIV зууны үеийн яруу найрагч Чойжи-Одсэр, УБ., 1969.